

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

АНХАГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 39 (2303)

1974 оны 5 дугаар сарын 20

ДАВАА

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭД-ИХ ХҮЧ

МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ажиллах хүчний ноогийг нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчдийн хэсгийг хөдөө аж ахуйд шилжүүлэн ажиллуулах чухал шийдвэр гаргасан билээ.

Үүний дагуу ХАА-н үйлдвэрлэлд 700 шахам охид, хөвгүүд МХЗЭ-ийн илгээлтээр гарч ажиллан тэд 83 мянган мал хариуцан малаж, 10,7 мянган га талбайд үр тариа, төмс хүнсний ногоо тарьж түүнийг арчлан ургуулж байгаа юм.

Бүх ард түмний уралдааны жил—1973 онд илгээлтийн эзэд 45,6 мянган төл бойжуулж 696,1 мянган литр сүү сааж, 27,7 мянган тонн байгалийн хадлан бэлтгэж нэг сая гаруй төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Баян-Өнжүүл сумын хоньчин О. Цэвэгмид, Өндөрширээт сумын тракторч Н. Болд, Жаргалантын САА-н ногоочин Ц. Сувдаа нарын илгээлтийн эзэн 14 хүн улсын аварга, Баянжаргалан сумын үхэрчин Д. Дампүрэв, Угтаалын САА-н хоньчин Ж. Мөнхтөр, Жаргалантын САА-н тахиачин Нэргүй нарын 27 илгээлтийн эзэн аймаг, сумын аварга цол хүртлээ.

1971 оноос хойш илгээлтийн эздийн дотроос ажил үйлсээрээ шалгарсан 32 залуу байгууллагынхаа зардлаар ЗХУ болон ах дүү социалист орнуудад жуулчиллаа. Баяндэлгэр сумын ногоочин Н. Амгалан, Батсүмбэрийн САА-н саальчин Ш. Пүрэвжав, Баян-Өнжүүл сумын хоньчин М. Удаа, Жаргалантын САА-н тракторч С. Тавандэрэг нарын 18 залуу МХЗЭ-ийн Төв Хорооны алтан медальнар шагнагдав.

Өнгөрсөгч онд ургацын төлөвлөгөөг 399 хувь биелүүлсэн Батсүмбэрийн САА-н ногоочин Х. Хандаа, үнээ бүрээс 1000 литр сүү саасан Эрдэнэ сумын "Туяа" нэгдлийн саальчин Г. Мямарсүрэн, 100 хээлтгүч тутмаас 100—103 төл бойжуулсан Лүн сумын "Энхтуул" нэгдлийн хоньчин, Нэгдэлчдийн IV их хурлын төлөөлөгч Ц. Чанцалдулам, Баянцагаан сумын хоньчин Г. Лхамсүрэн, Баян сумын ямаачин Г. Шарасамбуу нарын таван жилийн гавшагчдын тэргүүн эгнээнд хошуучилж яваа сайчууд олноор төрөн гарч байна. Ахмад тэргүүний ажиллагаатай 167 хүнийг 429 залуу дагалдан ажиллаж, тэдний арга туршлагаас цуцалтгүй суралцаж байна.

Малчин илгээлтийн эзэд 47856 мал төлдүүлж, мянга шахам төл илүү бойжуулж байгаагийн дээр 225 малчин залуу ганц ч малын гарзгүй тавтай сайхан хаваржиж байна. Илгээлтийн эзэд ийнхүү үйлдвэрлэл дээр үр бүтээлтэй ажиллахын зэрэгцээ ерөнхий боловсролоо цуцалтгүй дээшлүүлж VIII ангид 233, IX ангид 83, X ангид 27 залуу орой, эцнээгээр сурч байна. Жаргалант, Угтаал, Лүн, Батсүмбэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Борнуур сумын эвлэлийн байгууллага илгээлтийн эзэдтэй тодорхой ажиллаж, жил бүр чуулга уулзалт, зөвлөлдөөн хийж ажлыг нь дүгнэх, шинэ зорилт дэвшүүлэх, хөдөлмөр соёлын аян зарлах, ахмад хүмүүсийг дагалдуулан ажиллуулах, багшин уулзалт зохиох, болзолт уралдаан зарлаж шалгарасдыг тойрон аялал, жуулчлалд оролцуулах, тэргүүн туршлагын сургууль хийх зэрэг олон хэлбэрийн ажлыг зохиож байгаагийн дунд илгээлтийн эзэд тогтвор суурьшилтай ажиллаж, амжилт бүтээлээр ахуй байна. Удахгүй хэдхэн хоногийн дараа 7 дугаар анги төгсөгчдөөс 700 гаруй охид хөвгүүдийг эвлэлийн илгээлтээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр гаргах гэж байна.

Иймд нэгдэл, сангийн аж ахуй бүр илгээлтээр очих залуучуудыг хүлээн авах, тэдэнд тодорхой ажил олгох, тэднийг халамжилж тогтвор суурьшилтай ажиллуулах бүхий л бололцоог сайтар хангах нь чухал. Ингэж ерөнхий эрдмийн зохиох боловсролтой олон залуучууд хөдөө аж ахуй дээр гарч ажиллаж байгаа нь шинжлэх ухааны ололт, тэргүүн туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ахмад малчдын халаагч нэр төртэй залгамжлах, хөдөө нутагт соёл түгээх боломж олгож мал, аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх хэтийн сайхан ирээдүйг нээж байна.

ОЙН ӨМНӨ

Аймгийн Тэврийг удирдах газрын деспетчир Ишдаш авто тэврийн байгууллагад 24 жил ажиллаж байгаа ахмад ажилтны нэг юм.

Тэрээр энэ хугацаанд орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлж иржээ. Деспетчир Ц. Ишдаш бүх ард түмний социалист уралдааны жил—1973 оны төлөвлөгөө болон уралдаанд авсан үүргээ 250 хувиар биелүүлж хамт олноо хошуучилжээ.

Ц. Ишдаш БНМАУ-ын тэврийн байгууллагын 50 жилийн ой угтаж 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд авсан

үүргээ амжилттай биелүүлж байна.

Деспетчир Ц. Ишдаш энэ оны эхний хагас жилийн орлогын төлөвлөгөөг 5 дугаар сарын 15-ны байдлаар 127,7 хувиар биелүүлжээ. Ингэснээр 1974 оны орлогын төлөвлөгөөг аймгийн намын XVI бага хурлын өмнө буюу 6 сарын өмнө биелүүлэх боломжтой болжээ.

Ц. Ишдаш энэхүү олон амжилтандаа тулгуурлан 50 жилийн ой угтаж V таван жилийн орлогын төлөвлөгөөг 6—8 сарын өмнө биелүүлэх үүрэг амлалт аваад урам зоригтой ажиллаж байна.

П. ДАМБАДАРЖАА



Баянжаргалан сумын "Шинэ-амьдрал" нэгдлийн Баян-эрхтий бригадын тэмээчин Р. Насанбат бүх ард түмний социалист уралдааны жил—1973 онд бөтгөө хорогдолгүй бойжуулж аймгийн аварга цолыг хоёр дахь удаагаа хүртсэн юм. Тэрээр тэргүүний тэмээчдийн улсын зөвлөлдөөнийг угтаж 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд үүрэг амлалт аваад урам зоригтой ажиллаж байна.

С. БОЛД-ын зурсан зураг

ТАРИАЛАЛТЫН ЯВЦЫН МЭДЭЭ

Аймгийн хэмжээгээр 5 дугаар сарын 15-ны байдлаар 94,8 мянган га-д үрлэлт хийж төлөвлөгөөний 79,4 хувийг биелүүлээд байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10,9 хувиар давуутай байна.

Борнуур, Угтаал, Заамар, Лүн, Өндөрширээт, Архустын тэжээлийн аж ахуй, Алтанбулаг, Баян, Баяндэлгэр зэрэг сумд улаан буудай, арвай, овъёос тариалалтын төлөвлөгөөг 100,0—149,3 хувиар биелүүлээд байна.

Тариалалтын сумдаар үзүүлбэл: (хувиар)

Сумд	Нийт үү-тал-нээс бай	үр тариа
Алтанбулаг	29,4	101,6
Батсүмбэр	65,9	92,1
Баян	29,6	100,0
Баян-Өнжүүл	29,0	100,0
Баяндэлгэр	53,8	149,8
Баянжаргалан	24,6	100,0
Баянзүрх	0	—
Баянцагаан	18,7	100,0
Баянцогт	69,8	77,9
Борнуур	46,7	76,9
Бүрэн	33,4	100,0
Дэлгэрхаан	0	—
Жаргалант	70,0	81,3
Заамар	3,4	97,0
Лүн	61,9	95,3
Мөнгөнморьт	24,7	100,0
Өндөрширээт	91,6	101,0
Сэргэлэн	1,8	—
Угтаал	99,0	99,8
Эрдэнэ	82,9	85,5
Эрдэнэсант	91,8	91,8

Статистикийн товчоо

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРЛЫН ӨМНӨ

1976 ОНЫ АЖИЛД ОРСОН ЗАМЧИД

Аймгийн Зам ашиглалтын ангийн дарга Н. Лувсанчүлтэм Зам тэврийн байгууллагад 20 гаруй жил ажилласан туршлагатай зохион байгуулагч төдийгүй шинийг санаачлагчдын нэгээ.

Түүний санаачлан хийсэн төмөр бетон хоолой нь техникийн нөхцөлийн хувьд 20 жил эдлэгдэх бүрэн найдвартай, модон хоолойноос 2,5 дахин бага зардал гаргаж, хөдөлмөрийн бүтээмжийг 61,2 хувиар дээшлүүлэн өөрийн өртгийг 38 хувиар хямдруулж зөвхөн нэг ширхэг модон хоолой хийхэд зарцуулах хөдөлмөөрөөс 32 хүн өдрийн ажил хэмнэж байна.

Уул төмөр бетон хоолой Улаанбаатар, Булган,

Хэнтий аймгийн замын ангиудад нэвтэрч манай орны зам тэврийн нөхцөлд зохицсон хоолойноос жил бүр 353 төгрөгийн хэмнэлт улсад өгч байна.

Н. Лувсанчүлтэм өөрийн байгууллагын ажлаас ярихдаа: —Манай анги 1300 км урт зам, 1500 метр гүүр, 900 орчим хоолой хариуцан зам барилга засварын ажил гүйцэтгэж байна.

Хүмүүсийн идэвх хөдөлгөөнийг өрнүүлэхэд социалист уралдааныг удирдлагын гол арга болгож, машин техникийн хүч чадал, ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, үйлдвэрлэлд шинэ санаачилга тэргүүн туршлага нэвтрүүлэн ажилласнаар сүүлийн 3 жилийн төлөвлөгөөг 127,2—226,9 хувиар биелүүлээ гэж ярих.

Тус ангийнхны V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жил 3 сарын дүн гарчээ. Зам ашиглалтын ангийн хамт олон V таван жилд 2,5 сая төгрөгийн зам засварын ажил гүйцэтгэх төлөвлөгөөг 1 жил 9 сарын өмнө 103,3 хувиар биелүүлж 29,3 мянган төгрөгөөр давуулан биелүүлж 1976 оны ажилд оржээ.

Ахмад замчин, мужаан Д. Содном гуай нас 67 хурсд ч залуустайгаа уралдаж V таван жилийн төлөвлөгөөг 2 жил 10 сарын өмнө 105,5 хувиар биелүүлж замчдыг хошуучилж явна.

Р. БАЯРСАЙХАН

НИЙТ СУРГУУЛИУДЫГ УРИАЛЖ АВСАН ҮҮРЭГ

1975 онд болох улсын багш нарыг зөвлөлгөөнийг угтаж 1973 онд байгуулагдсан Тов аймгийн төвийн 8 жилийн дунд сургуулийн хамт олон бид нийт сургуулийг уриалж доорх үүргийг авч байна.

—Тойргийнхоо сургуулийн насны хүүхдийн судалгаа гаргаж, нэг ч сурагчийг завсардуулахгүй сурган, улсын төлөвлөгөөг бүрэн биелүүлнэ.

—Сурлагаар —хоцорч яваа сурагчдын судалгаа гарган нэг бүрчилэн ажиллана.

—1974—1975 оны хичээлийн жилийн эцсийн дүнгээр онц ба сайн сурлагатай хувийн жинг өмнөх оноос нэмэгдүүлнэ.

Сэдэв бүрээр сурагчдын мэдлэгийг дүгнэж, хоцрогдлыг цаг тухайд нь илрүүлэн засах талаар багш бүр тодорхой ажиллагч программыг чанарын хувьд бүрэн биелүүлнэ.

—Хичээлд сургалтын техник хэрэгслийг өргөн ашиглана. Үзүүлэх туршлага, дадлага, сорилтын ажлын жагсаалтыг гарган бүрэн хийнэ.

—Сургалтын дэвшилт арга барил, ЗХУ, өөрийн орны сургууль, багш нарын туршлагыг багш нарт эзэмшүүлэхэд заах аргын ажлыг чиглүүлэн тусгай графикаар 7 хоногт нэг удаа үзүүлэх хичээл хийнэ. Багш бүр 3—аас доошгүй заах аргын сэдэв боловсруулж хэлэлцүүлнэ.

—Хими, физик, биологи, мужаан, дархан, гэр ахуйн кабинетийг тоноглон төхөөрөмжилж гэрчилгээтэй болгоно. Хэл бичиг, уран зохиол, орос хэл, түүх, тоо, газар зүйн анги, кабинет, бага ангийн заах аргын кабинетийг байгуулж тохижуулна.

—Сурагчдын сурах хүмүүжих үйл ажиллагаанд өөрсдий нь оролцуулах талаар 2—оос доошгүй оновчтой арга хэлбэрийг туршин хэрэглэнэ.

—Залгамж үеэ 2 жилийн аяны хугацаанд тэргүүний бүлэг, салаа, зөр-

чилгүй хамт олон болох, соёлч нөхөрлөлийн хөдөлгөөнд оролцох талаар анги бүлэг бүрийг үүрэг авч ажиллуулна.

Таван онцыг эзэмшигч, номын сайн нөхөр, «Д.Нацагдорж» тэмдэгтийн тоог 1973 оныхоос 50 хувь нэмэгдүүлнэ.

Төгсөх ангийн сурагчдын дунд «Хөдөлмөр бүтээлээ дурсган үлдээе» гэсэн хөдөлгөөн өрнүүлж, нэг шинэ зүйлийг бүтээж үлдээлэг уламжлал тогтооно.

—Сурагчдын зохион бүтээх чадвар, урлагийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор залуу техникчдийн дугуйлан, гитар, шанзны чуулга байгуулан ажиллана.

—Тойрон аялал экскурсийг 2-оос доошгүй удаа зохиож орон нутгийн материалаар кабинетаа баяжуулна.

—Шеф бригадын 16-49 насны хүмүүсийн 30 хувьд доошгүйг боловсролоор шат ахиулна.

Илгээлтийн эзэдтэй байнгын холбоо тогтоон, ажил амьдралд нь зүйл бүрийн туслахаа үзүүлж байхын зэрэгцээ, тэдэнд 10 жилийн боловсрол олгох ажлыг хариуцна.

—Төлөвлөлийн дэвшилтэй хэлбэрийг сургууль, багш нар ажилдаа нэвтрүүлэн холбогдох журам заавар боловсруулна.

—Сургуулийн дотоод хяналт, шалгалтын ажлыг сургалтын чанарыг дээшлүүлэхэд чиглүүлэн сургуулийн захиргаа 7 хоног тутам 25-аас доошгүй цагийн хичээлд сууж байхаас гадна, сар тутам тоо, хэл бичиг зэрэг хичээлээр бүх анги бүлгийг шалгаж байна.

—Багш нарын хөдөлмөрийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар хөдөлмөр хөнгөвчлөх 2-оос доошгүй арга хэлбэрийг сургууль, багш нарын ажилд туршин хэрэглэнэ.

—Багш нарын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор хичээлийн

бэлтгэлд хэрэглэх бүх төрлийн гарын авлага, сурах бичгээр бүрдсэн, сууж ажиллахад тохиромжтой заах аргын танхим байгуулна. Багш нар тур амрах, хүүхдээ саатуулах тусгай тасалгаа гаргаж, багш нарт халуун цай, хоолоор үйлчлэхийн зэрэгцээ багш нарын зуны амралтыг ашигтай зохион байгуулна.

—Багш нарын 70—аас доошгүй хувь нь хувийн бүтээлч төлөвлөгөөтэй ажиллана. Эцэг эхийн хороо, зөвлөлийн идэвхт нүүдийн үүрэг хариуцлагыг нарийн тодорхойлох, эцэг эхийн лекц, хурал, зөвлөлгөөнийг анги бүлгээр төрөлжүүлэн системтэй явуулах, албан газруудаар тусгай дэвтэр аялуулах замаар сургууль, гэр бүл, албан газрын холбоог бэхжүүлнэ.

—Барилга засварыг жил бүрийн 7 дугаар сарын 1—ний дотор чанартай хийж, нэгэнт засварласан анги танхимыг сургуулиа төгсгөл нь хариуцуулахаар бодож сурагч, багш, эцэг эхэд хүлээлгэн өгөөд анги танхимыг засваргүй, эд хогшилыг өвдрлэгийг эдлэх хөдөлгөөн өрнүүлнэ.

—Байрны сурагчдын хоолны нэр төрөл, амт чанарыг сайжруулахын тулд ногоо, цагаан идээ, байгалийн баялгийг өргөн хэрэглэнэ.

—Пионерийн танхим, уншлагын танхим, 50 хүүхдийн дотуур байр, гал тогооны газар, газар зүйн ажиглалтын талбайг шинээр байгуулж тохижуулна. Шеф бригадыг түшиглэн хөдөлмөр амралтын зуслан байгуулж сурагчдыг ээлжээр ажиллуулна.

Сургуулийн ногооны аж ахуйн талбайг шинээр байгуулж түүнээс байрны сурагчдын хоолонд хэрэглэх хүнсний ногооны 20—иос доошгүй хувийг авч байхаас гадна олон наст ургамлын үрийн талбай байгуулна.

Сургуулийн хамт олны хурлаар хэлэлцэж батлав.

Даалгасан ажлыг хариуцах хариуцлагыг дээшлүүлсэ

Саяхан Лүн сум-нэгдэл албан газруудын дарга, эрхлэгчид, мэргэжлийн сэхээтнүүдийн эрхэлсэн ажил, мэдлэг боловсролоо дээшлүүлж байгаа хувийн хариуцлага сахилга батын байдалд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас шалгалт хийлээ.

Шалгалтанд дээрхи албан тушаалтнуудаас гадна бригадууд тэжээл эмчилгээний цэг, 20 шахам суурь, 60 гаруй малчид хамрагдав.

Тус сумын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилт 1973 онд амжилттай биелэгдэж ялангуяа ургац авалтаар үлсад байр эзэлжээ. 1974 онд төл бойжуулах ажлын явц, бэлтгэлийн болон бусад төлөвлөгөөт ажил 1973 оны мөн үеийнхээс зарим төрөл нь ахицтай биелэгдэж байна.

Гэвч тус сумын ажил жигд сайжрахгүй удирдах болон мэргэжлийн боловсон хүчнүүдийн ажлын хариуцлага, санаачилга, бие даасан бүтээлч ажиллагаа сул, албан байгууллагуудын дотоод аппаратын зохион байгуулалт, эмх цэгц хангалтгүй, хяналт шалгалт хоцрогдонгүй байна. Хорин таван

хүний ажлыг судалж үзэхэд 65 хувь нь жилийн, 72 хувь нь сарын ажлын төлөвлөгөө, өдрийн авсан үүрэг даалгаврын дэвтэргүй, 16 хувь нь гарын авлага болох эрхэлсэн ажлын холбогдолтой хууль зүйн лавлахгүй, 44 хувь нь ажлын тодорхой судалгаагүй, 56 хувь нь 1974 онд ганц ч ном уншаагүй, 72 хувь нь сүүлийн үед гарсан нам, засгийн чухал тогтоолуудыг мэдэхгүй байна.

Сум—нэгдлийн ерөнхий зоо-техникч Н.Балжин тус суманд 8 жил шахам хугацаанд ажиллахдаа эрхэлсэн ажилдаа тодорхой үр бүтээл гаргасангүй.

Н. Балжин 1973 онд өөрөө хийхээр 23 асуудал

төлөвлөснөөс ганц нь ч бүрэн биелэгдсэнгүй Эрхэлсэн ажлын судалгаагүйгээс хээлтүүлэгч хээлтэгчийн тохироо алдагдал хүрч байна. Жишээ нь Тус сум-нэгдэлд үржилд тэнцэхгүй хээлтүүлэгчийн тухайн үед нь заазахгүй байснаас хуц 300, бүх 55-ыг саяхан хөнгөлж нилээдийг хоргодуулсан байна.

Мөн үнээний зохиомол хээлтүүлгийн улсын төлөвлөгөөг 3 жил дараалан тасалж 1972 онд нэг ч үнээнд зохиомол хээлтүүлэгч хийгээгүй байна.

Нэгдлийн тооцооны нябон Н. Жигмэдцэвэрн удаа дараалан архи хэтрэлтээ ууж ажил тасалж хөдөлмөрийн сахилга бат алдаж эрхэлсэн ажлаа хариуцахгүй байгаа явдал илрэв.

Санхүүгийн аппаратын хүмүүс бригадын дарга, тоо бүртгэгч нар малын тооллого, тооцоог тухайн хугацаанд хийхгүй будлантуулж анхан шатны бүртгэлийг бригад, суурьт нэвтрүүлээгүй, өр төлбөр нэмэгдсээр байна.

Социалист уралдааныг эрчим муутай зохион хэлбэрдэж хүмүүсийн идэвхтэй үйл ажиллагаа болгож чадаагүй байна.

Тус суманд малын зүй бусын хоргодол 1973 оны энэ үеийнхээс 32 хувиар өссөн байхад хорогдлыг зогсоох талаар шийдвэртэй арга хэмжээ авахгүй байна. Эдгээр дутагдал нь удирдах болон мэргэжлийн боловсон хүчнүүдийн хувийн хариуцлага сахилга бат муу байгааг харуулж байна.

Иймээс аппаратын дотоод эмх цэгц, хувь хүний үүрэг хариуцлага, мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар байнга тогтмол ажил зохиож хяналт шалгалтын ажил эрхэлсэн байгууллагууд хоорондоо холбоо уялдаатай шалгалтын нэгдмэл системтэй ажиллах нь чухал юм.

Г. НЯМБУУ

ЗУН ЦАГИЙН СПОРТ

Хаврын урь орж, байгаль дэхийг сэргээн, шинэ хэн ногоо соёолж, төрөлх оронд минь зуны сайхан цаг айлчлан ирж байна.

Манай тамирчид 1974 онд өвлийн спортын төрлүүдээр явагдсан уралдаануудад амжилттай бэлтгэж оролцсон бөгөөд БНМАУ-ын спортын мастерын нормьм 1 тамирчин, 1 дүгээр зэргийг 4 тамирчин биелүүлсэн юм.

Харин баг, тамирчдын хувьд улсын тэшүүрт 11, цанад 10 дугаар байранд оролоо. Энэ нь өвлийн спортын төрлийн бэлтгэл сургуулийг зун хийлгүй орхисноос болов.

Иймээс зун цагт хийгдэх спортын бэлтгэл сур-

гууилтыг эхлэх, зохих бэлтгэлийг хангах цаг бараг оройтож байна.

Бүх ард түмний социалист уралдааны жил 1974 онд Монголын эмэгтэйчүүдийн анхдугаар, хөдөөгийн залуучуудын 3 дугаар спартакиад орон даяар явагдах болно.

Манай оронд анх удаагаа зохиогдох гэж байгаа кросс уралдааны улсын аварга, хөнгөн атлетикийн зэрэг ахиулах тэмцээн, идэрчүүдийн хөнгөн атлетикийн найрамдалт 4 төрлийн тэмцээн, хөнгөн атлетикийн идэрчүүдийн улсын аварга шалгаруулах уралдаан тэмцээнүүд болно. Эдгээр тэмцээнүүдэд нийт байгууллага, багш,

дасгалжуулагчид, тамирчид бэлтгэлийн эрх хүчийг нэмэгдүүлж, спортын материаллаг баазыг бэхжүүлэхэд бололцоотой бүх арга хэмжээг авах шаардлагатай байна.

Саяхан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ХБХБ тэмдгийн шинэчилсэн иж бүрэн норм батлаж 1974 онд зохих бэлтгэлийг нь хангах, 1975 оны 1 дүгээр сарын 1-нээс шинэ нормоор шалгалт авахаар тогтоол гаргалаа.

Зуны цагийн спортод бэлтгэх асуудал бол дээрхи уралдаан тэмцээнүүдэд бэлтгэх, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэх ёстой.

Дээр дурдсан спартакиа-

дуудад амжилттай бэлтгэхэд нам, олон нийтийн байгууллагууд, биеийн тамирын багш, мэргэжилтнүүд, нийт хөдөлмөрчид, тамирчид, сум, хот, хороо, сургууль, албан байгууллага бүхэн цана, тэшүүр, хөнгөн атлетик, сагсан бөмбөг, волейбол, үндэсний болон бөхийн чөлөөт барилдааны төрлүүдээр секс дугуйлангуудыг байгуулж хичээллүүлэн байгууллагын ба залуучуудын нэрэмжит шигшээ багуудыг байгуулж ажиллуулах нь чухал.

Зуны спортын бэлтгэл ажлын чухал хэсэг нь сум, САА, сургууль, албан газруудын дэргэдэх биеийн тамирын талбайнуудыг засч тохижуулах, шинээр барьж байгуулах, нэгэнт

байгуулсан биеийн тамирын талбайдаа гүйлтийн зам, урт өндрийн харайлт, волейбол, сагсан бөмбөгийн талбай, теннисний ширээ, гимнасткийн зарим бололцоотой хэрэглэж материалуудыг байрлуулан байнга ашиглалттай байлгах явдал мөн.

Спортын төрөл бүрийн тэмцээн тоглолтуудыг зуны улирлын төлөвлөгөөт ажлуудтай холбож, байгууллага, албан газруудын хооронд уулзалт, уралдаан тэмцээнүүд зохиож явуулах, мөн тэмдэглэлт ой, байгууллага, газрын нэрэмжит тэмцээнүүдийн тоог олшруулах, явагдаж байгаа уулзалт тэмцээн, тоглолтоо өргөн сурталчилж байх хэрэгтэй.

Ж. ДАГВА

ТАВАН БҮРИЙН ТӨЛӨӨ

АВДАР БРИГАДЫНХАНЫ АМЖИЛТ

Авдар бригадын дарга Д. Шаравтай зам нийлж суурь бригадын ажилтай нь танилцахаар баруун Өлийн даваа, Авдар-уулын ар хоолой, Хөгнө, Эрдэнэ, Авдар уулсын хавь нутгаар явахад уулын бэл хоолойгоор мал сүрэг багцран бэлчээрлэнэ.

— Манай бригад 40 гаруй мянган малтай 4 хэсэгтэй, энэ жил 17,5 мянган мал төлөхөөс одоо 15,0 мянган мал төлөж гарсан төлөө 99,3 хувиар бойжуулж, малын зүй бүсын хорогдлыг өнгөрсөн оны мөн үеийнхээс 50 гаруй хувиар багасгаж тарган тавтай хаваржиж байна. Хоньчин Ж. Сүрэнжав, Д. Пунцаг, Ж. Дагважанцан, тэмээчин Д. Зэсэм нарын 10 гаруй суурь төлөө сайн бойж уулж МАХН-ын Төв Хорооны IX тусгай хурлын шийдвэрт танилцуулжээ.

Манай сууринд Авдарын ар, Хүйтэн, Сэрүүн, Өөлд, Сөдгий, Долоон, Тэрвий зэрэг ус бэлчээр тэгш нутгаар мал ногоолох отор хийж байна.

Бригадын тэмээний эр ноосны төлөвлөгөөг биелүүлж, ямааны ноолуурын 90 хувийг 1 дүгээр зэрэгт тусгаалаа гэж бригадын дарга Д. Шарав ярьж явав.

Нар баруунаа хэвийх үед адуучин залуу Л. Дам бадаржаагийн суурьт ирэв.

Суурийн ахлагч Л. Дам-бадаржаа;

— Манай суурь 400 гаруй адуутай 110 гүү унагалахаас 70 гаруй гүү унагалж төл бүрэн мэнд бойжиж байна.

Мал тарган орсон болохоор хөөвөр хялгасыг цагалдалгүй авахын тулд өдөр адуугаа хөөвөрлөж аль ногоо сайтай газар манаж байна.

Адуучид бидний хамгийн хариуцлагатай цаг гүү унагалах, хөөвөр хялгас авах, ногоолох, эмнэг хангал сургах энэ үе юм.

Адууны хариулга, маллагааг сулруулахгүй байх нь энэ жилийн суурийн төлөвлөгөө биелэх төдийгүй ирэх жилийн өвөл хаврын бэлтгэл юм гэж ярих.

«Авдар» бригадынханы мал ногоолох үеэр хужир шүүгээр сууриудыг хангахаар «Шаварт нуудгай»-гаас хужир татах бригад ажиллуулж, өвлийн бэлтгэл зориулан суурь бүр хужир хамаа даалгавартай ажиллаж байна.

Богийн саалийг богино хугацаанд ашиглахын тулд масло боловсруулах нүүдлийн хэсэг байгуулж, Хүрээт, Зүлэгт, Баянгийн, хоолой, Гүн худал зэрэг газраар отор хийж малаа таргалуулж, сааль сүүгээ ашиглахаар шамдаж байна. Ийнхүү «Авдар» бригадынханы ажил үйлс өөдрөг байна.

Р. БАЯРСАЙХАН

Мэргэжилтний зөвлөлгөө

НЯЛХ ТӨЛ АРЧЛАХ ЗАРИМ ОНЦЛОГ

Төлийг усах, Нялх төлд ус дутагдахад бодисын солилцоо хямарч, тэжээлийн ууршил үгүй болж биеийнх нь өсөлт хөгжилт удааширч улмаар биеийн эсэргүүцэл суларна. Ус дутагдсанаас төлийн цус, тунгалаг зэрэг шингэнүүд нь өтгөрнө. Мөн цусны унжгай (вязкость) чанар нь нэмэгдэж төлийн зүрх судасны ажиллагааг хүндрүүлнэ. Цус тунгалаг төрснөөр ферментийн (исгэг) ажиллагаа буурна.

Иймд төлийг усаар хангах асуудлыг шийдвэрлэхдээ төлийн өсөлт, хөгжилтийн эхний үеийг сайн анхаарах шаардлагатай.

Нялх төлд эхээс гарснаас хойш 3—4 дэх өдрөөс нь эхлэн ус өгөх бөгөөд төлд өгөх ус нь 20

градусаас дээш байвал сайн. Боломжтой үед төлд өгөх усыг буцалгаад хөргөж өгвөл ашигтай.

Төлийг усанд дасгахдаа хоёр удаагийн хөхөлтийн хооронд бага зэрэг давс нэмсэн шорвогдуу усаар угжна. Төлд онгоц, түмэн саванд ус хийж тавихад бага багаар амссаар усанд орно.

Тэжээл. Төл малыг заавал тэжээх шаардлагатай.

Ялангуяа төлийн өсөлт хөгжилт явагдаж байх үед нь эрдэс бодисоор хангах нь төлийн өсөлтөд их ач холбогдолтой юм. Төлийг 7—10 хоногийн бойжилттойгоос нь тэжээлд дасгана. Эрдэс бодис төлд дутагдахад ясны хөгжилт саатаж яс зөөлөрнө.

Витамиинууд дутагдвал олон төрлийн өвчнүүд үүснэ. Ийм учраас төлд зохих хугацаанд нь хурааж сан чанар сайтай ногоон өвсийг хэц татаж жижиг жижгээр нь боож дүүжилж өгөх хэрэгтэй.

Байр. Төлд физиологийн онцлогт нь тохирсон байр чухал. Төлийн байр нь саруул уужим, чийггүй салхи нэвт үлээдэггүй байх ёстой. Төлийн байр давчуу гэрэл муутай бол чийг татаж шүвтэр, хүхэр ус төрөгч цугларч нүдний салст бүрхэвчийг өрөвсүүлж өвчлүүлнэ.

Төлийн байрны хэвтрийг өдөр бүр цэвэрлэж, шинэ хуурай бууцаар сольж төлийг өдөр 11—15 цаг хүртэл нарлуулах хэрэгтэй.

Д. ЕНДОН

АЖИЛ САЙТАЙ БУХЧИН

Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн «Алтанбулаг» бригадын Шарав ахлагчтай шилмэл монгол үнээний суурийн бух маллагч М. Жамбал үнээний хээ сувайралтыг 27 хувь багасган, хээл авалтыг 95 хувьд хүргэжээ.

Тэрээр 1973 оны зун дөрвөн бух хариуцан малласан юм. Тэрээр дөрвөн бухандаа тохирсон хашаа, мөн бухны шөнийн амрах байр барьж ашигласан нь бухаа ижилсүүлэх сайн арга болжээ.

Дөрвөн бухаа байранд нь нийлүүлэн дөрвөн буланд нь уядаг байна.

Бухнуудаа нэг хашаанд уяатай хонуулж сургахын хажуугаар төрөл бүрийн тэжээл идүүлж сургажээ. Ийнхүү гар маллагаанд сурч эхэлсэн бухнууд хоног өнгөрөх тутам хоорондоо ижилсэн дасжээ.

М. Жамбал бухандаа өдөрт 4—5 шанага (нэг шанаганд 800 грамм) няцалсан будаа, хивэгийн холимгийг хоёр хувааж, сүүгээр зуурч өгдөг ба амрах ээлжийн бухаа өдөр нь бэлчээж, бэлчээрээр

нь усалдаг байна. Дөрвөн бухаа хоёр хоёроор нь 4—6 өдрөөр ээлжлэн тавьж үнээ дагуулж байхдаа өглөө орой тэжээж, шөнө уяж амрах дэгийг нарийн баримталж байсан нь хээлтүүлгийн хугацаанд (6,7,8 дугаар сар)-ын туршид бухны идэвхи жигд, хээл тогтоох чадвар сайн байхын үндэс болсон байна.

Эдгээр ажиллагааны үрээр Шаравын суурийн үнээ бусад суурийнхаас илүү сайн хээл авдаг юм.

В. ДАВААДОРЖ

Өөдөс бүр хаягдал биш

Зарим үйлдвэрлэлийг явуулахад материалын нилээд хэмжээний өөдөс гардаг. Тухайлбал;

НААУГ-ын эсгүүрийн тасагт төрөл бүрийн даавууны, сонины үйлдвэрт цаасны өөдөс тухайн хийж буй зүйлийн стандарт, материалын хэмжээний байдлаас болж байнга гардаг билээ. Энэ бол үйлдвэрлэлийн явцад зайлшгүй гарах ёстой зүйл боловч тэр бүхэн хаягдал болох эд бишээ.

Даавууны өөдөс байтугай үртэснийг ашиглавал ямар хэрэгтэйг бид мэднэ.

Хүнсний ногооны үртэс ургуулах хөрсөнд 30 хувийн үртэс холиход хөрсний сийрэгжилт дулаан хадгалах чанар сайжирч ногооны соёлолт түргэн болдог тустай зүйл. Үртэсээр хийсэн понер энгийн понериас дутуугүй сайнаар хэрэгцээ хангадаг.

Ашиглаа гэсэн санаачилга байвал юуны ч өөдсийг ашиглаж болно.

Өнгөрөгч 1973 оны дунд үеэс аймгийн НААУ газар бээлий хийснээр 10900 гаруй төгрөг олсон туршлагадаа тулгуурлан өнөө жил өөдсөөр бээлий хийхээр 5 хүн дагнан ажиллуулж одоогийн байдлаар 14500 төгрөгийн бүтээгдэхүүн хийгээд байна. Түүнчилэн «Анхдугаар таван жил» сонины үйлдвэр 1973 онд өөдөс цаасаар тэмдэглэлийн дэвтэр хийж 3000 гаруй төгрөг, энэ онд 1200 төгрөг олжээ. Өөдлын үйлдвэрт материал түүхий эдийн зардал өөрийн өртгийн 79—85 хувийг эзэлдэг аж.

Тэгэхлээр энэхүү үнэт материалаас аль болох бага өөдөс гаргахын тулд үлгэрээ зөв байрлуулж эсгэхээс эхлэн нэгтгэн гарсан өөдсийг маш сайн ашиглах нь чухал байна.

Өөдсийг сайн ашиглаж бүтээгдэхүүн болгон борлуулснаар үйлдвэрийн дотоодын хуримтлалыг арвижуулах нэг эх булгийг нээж байгаа юм. Ингэх-

лээр өөдсөөр юу хийж болох вэ?

НААУГ-ын даавууны өөдсөөр бээлий, хивсийг өөлөхөд гарсан хигдэсээр сандлын зөөлөвч, дэр зэргийг хийхээс гадна нарийхан даавууг томож ширээд тугал, малын уяа ноот хүзүүвч, нэмээний оосор бүч, гутлын гувуур, хурганы элгэвч нэмээ манай малчдын ойр зуурын хэрэгцээний оосор бүч юу эс хийж болохсон билээ дээ. Өөдсөөр хийж болох зүйлийн нэр төрлийг хүний хэрэгцээний хирээр олшруулж болох зүйл. Харин ингэж үйлдвэрлэл явуулахдаа насны тэтгэвэрт гарсан хүмүүсийн эх оронч санаачилгыг өрнүүлэх замаар НААУГ-ыг түшиглүүлэн тусгай тасаг ажиллуулж ч болох юм. Ер нь материал зарцуулалтын улсын үзлэгийн өмнө нийт үйлдвэрүүд өөрийн материалын өөдөс хаягдлыг ашиглах боломжийг судлаж юмхаар юм хийх хөдөлгөөнийг өрнүүлвэл зүйтэй санагдана.

Ш. ЦЭРЭНДОО



Борнуурын САА-н тракторч аймгийн аварга Р. Даваахүү чухалга уулзалтын уриалсын дагуу 6 өдрийн ажлыг 5 өдөрт хийж төмс урэлээний ажилд бусдыгаа хошуучилж явна.

ЗУРАГ ДЭЭР: Тракторч Р. Даваахүү техниктээ тосолгоо үйлчилгээ хийж байгаа нь.

Л. ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг

Хөдөлмөрчдийн хууль ЭВЭН МЭДЛЭГТ

Манай оронд социалист үйлдвэрлэлийн харилцаа ялснаар социалист өмчийн эсрэг гэмт хэрэг үүсэн гарах нийгэм-эдийн үндэс үстсэн юм. Гэвч иргэдийн зарим хэсгийн дотор социалист өмчийг хулгайлах, завших, үрэгдүүлэх буюу бусад хэлбэрээр ашиглан шамшигдуулах гэмт хэргүүдийг үйлдэх явдал байсаар байна.

Социалист өмчийн эсрэг хэргүүдийн объект нь манай эдийн засгийн үндсийг бүрэлдүүлж байгаа үйлдвэрлэлийн багаж зэвсэг дээрх нийгмийн өмчийн харилцаанд халдаж байгаа явдал мөн.

Социалист өмчийн эсрэг гэмт хэргүүдийн эд зүйлс нь улс, хоршооллол, олон нийтийн байгууллагуудын өмчинд байгаа мөнгөн ба эд тавар, бүрэн ба хагас боловсруулсан бүтээгдэхүүн гэх мэтчилснийг өртөгтэй эд зүйлсүүд байна.

Харин цалин, хөдөлмөр өдрийн хөлс, бусад төлбөр зэрэгт зориулан иргэдийн амны өмчинд шилжүүлэхээр хуваарилсан мөнгө ба эд таварыг уг зэвсгийг өмчлөлд шилжээгүй байх үед ашиглан-шамшигдуулсан

бол социалист өмчинд халсан объектойд гэж үзнэ.

Мөн гэмт этгээд хулгайлахдаа уг зүйл хэний өмч болохыг мэдээгүй, мэдэхийг хүсээгүйгээр үйлдсэн үед уг зүйл улс, хоршооллын өмч байсан бол социалист өмчийн эсрэг (эрүүгийн хуулийн 63, 64 дүгээр зүйлээр), иргэдийн өмч байсан бол (эрүүгийн хуулийн 109 дүгээр зүйл) объектойд гэж ангилах ёстой.

Социалист өмчийн эсрэг гэмт хэргийн объек-

түүд нь уг этгээдийн идэвхтэй ба идэвхгүй ажиллагааны аль ч хэлбэрээр үйлдэгдэж болно.

Социалист өмчийн эсрэг гэмт хэргүүдийн субъект нь хулгай, дээрэм хоёроос бусад хэлбэрүүдэд 16 насанд хүрсэн, ух а а н мэдрэлийн хувьд хэрэг хариуцах чадвартай тус улсын ба гадаад улсын иргэн байна. Социалист өмчийн гэмт хэргийн субъектив тал нь социалист өмчийг устгах ба гэмтээх, улс, хоршооллын хөрөнгийг арчлан хамгаалах явдалд хайхрамжгүй хандах гэмт хэргээс бусад хэрэгт шунахай зорилготой, шууд

даасан байдлаар оруулан заажээ. Үүнд: нэгдүгээрт давтан үйлдэх гэдэг нь тус тустаа гэмт хэргийн бүрэлдэхүүний төсгөлгүй 2 дахин үйлдсэнийг хэлнэ. Гэхдээ анхны үйлдсэн хэрэгтээ эрүүгийн хуулиар ял шийтгэгдсэн эсэх нь хамаарагдахгүй.

Социалист өмчийг ашиглан шамшигдуулах гэмт хэргийн «давтан» үйлдсэнийг үргэлжлүүлэн үйлдсэн гэдэг ойлголтоос ялгах нь онол практикийн чухал ач холбогдолтой асуудлын нэг мөн.

Давтан үйлдсэн хэргийг үргэлжлүүлэн үйлдсэн хэргээс ялган үзэх гол шинж нь гэмт хэр-

Энэ хэргийн хүндрүүлэн үзэх гуравдугаар шалтгаан нь нийгэмд учирсан хохирол, ашиглан шамшигдсан зүйлийн тоо хэмжээ нь их бол хүндрүүлэн үзэх шалтгаан болгосон байна.

Харин хуулийн зүйл өөртөө их хэмжээ гэж чухам ямар хэмжээ ямар төрлийн эд материал байхыг заагаагүй учраас мөрдөн байцаах ба шүүн таслах байгууллагуудаас ашигласан зүйлийн тоо хэмжээ, улс ардын аж ахуйн ач холбогдол албан байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийн талаар нь шийдвэрлэдэг юм.

Ашиглан шамшигдуулах хэргийн хүндрүүлж үзэх дөрөвдүгээр шалтгаан нь урьд хулгай, дээрмийн хэрэгт шийтгэгдсэн этгээд үйлдэх явдал мөн.

Эдгээрээс гадна эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн «В-д социалист өмчийг онц хүндрүүлэх шалтгаантай үрэгдүүлэгчид хатуу хариуцлага» хүлээлгэхээр заахдаа 2-5 жил хүртэл хугацаа нутаг зааж суулгах буюу суулгахгүйгээр 8-15 жил хүртэл хугацаагаар хорьж бүр хөрөнгийг хураах буюу цаазаар авч бүх хөрөнгийг хураах онцгой ял оногдуулахаар тогтоосон байна.

СОЦИАЛИСТ ӨМЧИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

тив тал нь тухайн хэргийн хэлбэрээс үндэслэн үйлдсэн ба эс үйлдлийн аль нэг хэлбэрээр илэрнэ.

Жишээ нь: Социалист өмчийг хулгайлах, ашиглах дээрэмдэх (эрүүгийн хуулийн 64, 63), санаатайгаар устгах буюу гэмтээх (эрүүгийн хуулийн 65) гэмт хэргүүдийн объектив тал нь зөвхөн уг этгээдийн идэвхтэй ажиллагаагаар илэрнэ.

Гэтэл социалист өмчийг үрэгдүүлэх (эрүүгийн хуулийн 67), болгоомжгүйгээр устгах (эрүүгийн хуулийн 65) гэмт хэр-

санаатай хэлбэрээр илэрнэ. Социалист өмчийн эсрэг гэмт хэргүүдийг: Социалист өмчийг ашиглан шамшигдуулах гэмт хэргүүд-хулгайлах, ашиглах, үрэгдүүлэх бусад хэлбэрээр үрэгдүүлэн шамшигдуулах, социалист өмчийг дээрэмдэх, устгах ба гэмтээх, социалист өмчийн эсрэг бусад гэмт хэргүүд гэж 4 хэсэгт хуваан судалдаг.

Социалист өмчийг ашиглан шамшигдуулах хэргийг хүндрүүлэн үзэх шалтгааныг хуулийн зүйл дотор бие э

гийн бүрэлдэхүүний субъектив талын элементүүд төгссөн эсэхээр тодорхойлогдоно.

Хүндрүүлэн үзэх хоёрдугаар шалтгаан нь бүлэглэн үйлдэх; Энэ нь 2 буюу хэд хэдэн хүмүүс нийлж урьдчилан хэлэлцсэн ёсоороо ашиглан шамшигдуулах гэмт хэргийг аль нэгэн хэлбэрээр үйлдсэн байхыг хэлнэ.


Хамтран үйлдэгчид нь өмнө нь нийлж тохиролцсоноос гадна хэрэг үйлдэх үедээ нийлсэн хэлбэрүүдийн аль нь ч байж болно.

Эмэгтэйчүүдийн спартакиад

Монголын Эмэгтэйчүүдийн хороо, Монголын Биеийн Тамир Спортын Эвлэлийн Төв Зөвлөлийн Тэргүүлэгчдийн ба аймгийн Намын хорооны товчооны тогтоолоор эмэгтэйчүүдийн биеийн тамирын хөдөлгөөнд өргөн хамруулах зорилгоор эмэгтэйчүүдийн спартакиадыг явуулахаар шийдвэрлэсэн билээ.

Иймд эмэгтэйчүүдийн спартакиадын зорилго ач холбогдлыг өргөн сурталчлан бүх эмэгтэйчүүдийг хамруулан үзэл суртал зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахаар бэлтгэх зорилт тавигдаж байна. Эмэгтэйчүүдийн спартакиадыг волейбол, шатар, олон бөмбөг, хөнгөн атлетик зэрэг 4 төрдөөр 16-гаас дээш насны бүх эмэгтэйчүүдийг оролцуулж явуулна. Сум-нэгдэл, САА-гаас волейболоор 7, шатар 1, олон бөмбөг 1, хөнгөн атлетикийн төрлүүдэд 6 тамирчин тус тус шалгаруулан аймгийн спартакиадад оролцуулна. Сум-нэгдэл, САА-н тасаг, бригад албан байгууллагуудын эмэгтэйчүүдийн спартакиадад 1974 оны 5 дугаар сарын 18-19-нд, сумын спартакиадад 25-26-ны өдрүүдэд сум-нэгдэл, САА-н төвд, аймгийн спартакиадад 1974 оны 6 дугаар сарын 8,9-нд аймгийн төвд тус тус явагдана.

Ж.БАРХАС



ЗУРАГ ДЭЭР: Мытайнскийн машин үйлдвэрлэлийн заводоос үйлдвэрлэж байгаа газар доогуур явдаг цахилгаан галт тэрэг

ТАСС-ын гэрэл зураг

ТЭЭВРИЙН ХАНГАМЖ

Аймгийн Тээврийн удирдах газар 1973 оны авто нефть, бараа татан авалт, борлолтын төлөвлөгөөг 112—135 хувиар биелүүлж, 1972-1973 онд бараа эргэлтийн ажиллагааны зардлын нэгжийн хэмжээг 6,5 хувиар хямдруулан ашигт ажиллагааны түвшинг 23 хувиар өсгөж, фонд өгөмжийг 125 хувиар дээшлүүлсэн байна.

Социалист уралдааныг зохион байгуулах, дүнгээ түүнийг нийтийн хүртээл болгох зэрэг ажилд ахиц гарч хүн нэг бүрийн ажлыг богино хугацаанд тодорхой дүгнэдэг болсон нь ажилд амжилт гарахын үндэс болжээ.

Дотоод шаталтын төрөл бүрийн хөдөлгүүрийн хуучин тосыг эргүүлэн ашигласнаар «Зил-130» маркийн автомашин 10—15-ыг худалдан авах хэмжээний валютын хэмнэлтийг жил тутам олж байна. 1973 онд Баян-өнжүүл сум, аймгийн төвийн шатахуун түгээх станцууд нь шатахууныг хэмнэлтэй зарцуулах талаар багагүй ахицтай ажиллаж 21 тонн хуучин тос хураан авч буцааж ашиглажээ.

Гэтэл Ойн аж ахуй, НААУ-ийн газар, УААУ газар, Баяндэлгэр, Баянзүрх зэрэг сум, нэгдэл, албан байгууллагууд ша-

тахуун зарцуулалтад судалгаа тооцоо хангалтгүй хийж лиметийг баримтлахгүй, авто машин механизмуудад жинхэнэ гүйцэтгэх ажилд тохируулан шатахуун олгох журам орчин нормыг баримтлах явдал хангалтгүйгээс тосыг элдвэр хэлбэрээр хаяж үрэгдүүлэх явдал ихсэж үлэмж хэмжээний шатах тослох материалыг үр ашиггүй зарцуулж байжээ.

Авто сэлбэгийн ашиглалтыг сайжруулахын тулд шинээр сэлбэг хэргэсэл дугуй агрегатыг олгоходоо хуучин орыг хураан авч бололцоотой зүйлийг засварлан эргүүлж ашиглах, их засварын завод газруудаар засвар хийлгэж хэрэгцээг хангах, цаашдаа ашиглах боломжгүй хэсгийг хаягдал төмрөөр экспортод гаргахаар БНАМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 144 дүгээр тогтоолд то-

дорхой заасан билээ. Зөвхөн Тээврийн Яамны төмөр бэлтгэх контор хуучин төмөр сэлбэг материалаас 100 гаруй мянган төгрөгийн зүйлийг эргүүлэн ашиглаж засварын завод олон арван тооны агрегат эд ангийг их засварт шилжүүлэн их засварын дугуй хаягдал ширмээр дотоодын үйлдвэрүүдийн хэрэгцээг үндсэндээ хангаж байна.

Авто сэлбэг дугуй агрегатаар үйлдүүлэгч бүх сум, нэгдэл, САА, албан байгууллагууд төмөр бэлтгэлийн төлөвлөгөөтэй ажилладаг бөгөөд энэ ажлын эдийн засгийн ач холбогдлыг дутуу үнэлдэгээс Нэгдэл дундын үйлдвэр, Барилга угсралтын контор, УААУ газар, Баянцогтын САА, Сэргэлэн, Өндөрширээт, Дэлгэрхаан, Баян-өнжүүл сумд жил дараалан төмөр бэлтгэлийн төлөвлөгөөг тасалдуулж байгаадаа дүгнэлт хийх нь чухал байна.

Ш.МОНХБАЯР

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ЗАРЛАЛ

Баянжаргалай сумын харьяат Тулга овогтой Мэндбаяр нь 07656 тоот атестатаа, Батсүмбэрийн САА-н тракторч, комбайнч Намжил овогтой Зоригт трактор, комбайны 2 дугаар зэргийн жолоочийн 1249 тоот үнэмлэхээ гээгдүүлсэн тул тус тус хүчингүйд тооцов.